

“АРИГ ГАЛ” ХК-ИЙН 2024 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД

Гүйцэтгэх захирал Х.Ханиягаас тавих тайлан

Илтгэл

“Ариг гал” ХК–ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн эрхэм хувьцаа эзэмшигчдийн энэ өдрийн амгаланг эрин мэндчилье.

Тайлант хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагаас хийсэн ажлын тайланг Та бүхний сонорт хүргэх ялдамд цаашид ямар зорилго тавьж байгаагаа хүргэе.

Нэг. Борлуулалтын орлогын талаар

Тайлангийн хугацаанд компанийн хувьцаа эзэмшигчдийн өмнөх хурлаас дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхийн төлөө компанийн дүрмийн хүрээнд дараах үйл ажиллагаагаа зохицуулан явууллаа. Тайлангийн хугацаанд 5,965.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, төлөвлөгөөнөөс 41,2%-иар давуулан биелүүлж 11,926.0 сая.төгрөгийн орлоготой ажиллалаа. Үүнд:

1. Түрээсийн орлого өмнөх оноос 1.7 дахин өсч 1,277.6 сая төг болсон. Энэ цэвэр түрээсийн орлого болон Кашмер холдинг ХХК-д ашиглуулсан цахилгаан, дулааны төлбөр юм.
2. Таван толгой ХК-иас орж ирсэн ногдол ашиг өмнөх оноос 10,1 тэрбум төгрөгөөр өсч орж ирсэн.
3. Бусад орлого өмнөх онтой харьцуулахад 12,3%-иар буурсан. Энэ онд хүүгийн орлого 13.1 сая.төг орсон. Компанийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд ноосны үйлдвэрлэлийн үед хэрэглэж байсан илүүдэл сэлбэгүүдийг ангилан зарж борлуулах үйл ажиллагаа хийгдэж байгаа боловч ондоо багтаж орлого нь орж ирээгүй.

Хоёр. Зардлын талаар

2023 онд нийт 9,420,8 сая.төг-ийн зардал гарсан нь өмнөх оноос 1,7 дахин өссөн. Зардлын задаргааг харуулбал: Үндсэн үйл ажиллагааны зардал 1,956,3 сая.төг болж өмнөх оноос 55,8%-иар өссөн. Өссөн гол шалтгаан нь цахилгаан, дулааны төлбөр өссөн. Мөн бусдаас зөвлөх үйлчилгээ, бусад үйл ажиллагааны зардал өссөнтэй холбоотой.

1. Үйл ажиллагааны бус зардал /ханшны алдагдал/-7,460.5 сая.төг болсон. 2023 оны валютын огцом өсөлтөөс болж бусдад өгөх өглөг дээр 7,4 тэрбум төг-ийн ханшны алдагдал хүлээгдэж байгаа.
2. Ашгаас 70,0 сая.төг-ийг баяр ёслолийн арга хэмжээ, шагнал урамшуулал, буцалтгүй тэтгэмжид зарцуулсан

2022, 2023 оны бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл болон 2024 оны төлөвлөлтийг харуулбал:

| № | Үзүүлэлт | 2022 оны | | 2023 оны | | Өсөлт, бууралт | | 2024 оны төлөвлөгөө |
|---|----------------------------|-------------|-------------|-------------|--------------|----------------|---------|---------------------|
| | | төлөвлөгөө | гүйцэтгэл | төлөвлөгөө | гүйцэтгэл | Дүнгээр | %-иар | |
| 1 | Борлуулалтын орлого | 1,475,000.0 | 8,444,218.4 | 5,965,000.0 | 11,926,178.2 | 3,481,959.8 | 41,2 | 10,908,155.7 |
| | Үүнээс: түрээсийн | 400,000.0 | 713,228.7 | 750,000.0 | 1,277,651.1 | 564,422.4 | 79.1 | 1,280,000.0 |
| | Бусдаас авсан ноогдол ашиг | 675,000.0 | 492,289.7 | 5,200,000.0 | 10,635,380.1 | 10,143,090.4 | 2,060,4 | 9,613,155.7 |
| | Бусад орлого | 400,000.0 | 7,238,700.0 | 15,000.0 | 13,147.0 | (7,225,553.0) | (99.8) | 15,000.0 |
| 2 | Нийт зардал | 1,141,410.0 | 5,498,497.3 | 2,584,424.0 | 9,416,802.8 | 3,918,305.5 | 71,3 | 3,134,424.0 |
| 3 | Нийт ашиг | 333,590.0 | 2,945,721.1 | 3,380,576.0 | 2,509,375.4 | (436.345.7) | (14.8) | 7.773.731.7 |
| | Ашгаас санхүүжих зардал | 15,000.0 | 10,352.0 | 15,000.0 | 4,085.0 | (6.267.0) | (60.5) | 15,000.0 |
| | ААНОАТ | 50,000.0 | 692,100.0 | 200,000.0 | | (692,100.0) | (100) | 200,000.0 |
| | Цэвэр ашиг | 268,590.0 | 2,243,269.1 | 3,165,576.0 | 2,505,290.4 | 262.021.3 | 11.7 | 7,558,731.7 |

Гурав. Ашгийн талаар

2023 оны тайлан балансын орлогын тайлангаар 2,5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Татварын тайлангаар 612,5 сая.төг-ийн алдагдалтай гарч байна. Татварын тайлангаар алдагдалтай гарч ААНОАТатвар төлөхгүй ч бусад тайлангуудаар НӨАТатвар, ХАОАТ болон Эрх борлуулсны орлогын татвар, хүүгийн орлогын татвар, ноогдол ашгийн татваруудыг тайлагнаж төлсөн.

Ариг гал ХК нь тайлант хугацаанд улсын төсөвт **703.7** сая төгрөгийн татвар шимтгэл төлсөн. Үүнд:

| | |
|----------------|------------------------------------|
| НӨАТатварт | - 178.9 сая төгрөг, |
| НДШимтгэлд | - 77,3 сая.төгрөг, |
| Газрын төлбөрт | - 85.2 сая төгрөг, |
| ҮХХТатварт | - 53.2 сая төгрөг, |
| ХАОАТатварт | - 184.5 сая төгрөг |
| ААНОАТатварт | - 124.7 сая төгрөг тус тус төлсөн. |

Дөрөв.Санхүүгийн байдлын талаар

2023 оны тайлан балансыг харахад авлага өмнөх оноос 1,2%-иар өссөн. Кашмер холдинг ХХК-иас авах авлага 14,0 тэрбум төг-өөр өссөн. нийт авлага 63,8 тэрбум.төг болсон нь түүхий эдийн санхүүжилтээс гадна, 2023 онд хялгас ялгах болон ээрэх шугам авч үйлдвэрлэлийн сайжлуулалт хийсэнтэй холбогдох санхүүжилтээс шалгаалсан.

Өглөгийн хувьд өмнөх оноос 1,2%-иар өссөн нь Мөн ноос ХК-иас авсан зээл 19,7 тэрбум.төг, байгаатай холботой. Энэ нь түүхий эдийн бэлтгэлтэй холбоотойгоор охин компанийн эргэлтийн хөрөнгийн санхүүжилтээр үүссэн авлага болно. Урт хугацаат өглөг нь 2022 оны хуваарилсан нийгэмлэгүүдэд олгогдоогүй ногдол ашгийн өглөгөөр өссөн байгаа.

Ариг гал ХК-ийн 2023 оны жилийн эцсийн хураангуй БАЛАНС /мян.төг/

| БАЛАНСЫН ЗҮЙЛ | Үлдэгдэл | | Өсөлт бууралт | |
|---|---------------------|---------------------|---------------------|-------------|
| | 2022.12.31 | 2023.12.31 | дүнгээр | хувиар |
| А.ХӨРӨНГӨ | | | | |
| 1. Эргэлтийн хөрөнгийн дүн | 52,336,896,4 | 66,901,116,9 | 14,564,220,53 | 27.8 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 1,709,479,6 | 2,020,640,5 | 311,160,90 | 18.2 |
| Авлага | 50,600,478,9 | 64,853,538,5 | 14,253,059,62 | 28.2 |
| Үндсэн туслах материал | 26,937,9 | 26,937,9 | | |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | | | | |
| 2. Биет хөрөнгийн дүн | 2,542,738,0 | 2,419,355,1 | (123.382.96) | -4.9 |
| 3. Биет бус хөрөнгийн дүн | 525,963,3 | 524,327,5 | (1.635.76) | -0.3 |
| 4. Урт хугацаатай хөрөнгө оруулалт | 18,230,411,2 | 18,344,003,6 | 113.592.41 | 0.6 |
| Нийт хөрөнгийн дүн | 73,636,009,0 | 88,188,803,2 | 14.552.794.2 | 19.8 |
| Б. ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧД- ӨМЧ | | | | |
| 1. Өр төлбөрийн дүн | | | | |
| Богино хугацаат өр төлбөр | 61,919,985.9 | 74,324,624,5 | 12,404,638,6 | 20.0 |
| Урт хугацаат өр төлбөр | 797,772.4 | 950,407,4 | 152,635,05 | 19.1 |
| Үүнээс: Банкны хугацаа хэтэрсэн өр | | | | |
| 2. Хувьцааны дүн | 347,932,0 | 347,932,0 | | |
| Халаасны хувьцааны дүн | (10.398.8) | (21.469.3) | (11.070.47) | 106.5 |
| 3.Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг | 6,563,586,7 | 6,289,099,1 | (274.487.54) | -4.2 |
| 4. Хуримтлагдсан ашиг | 1,773,861.8 | 3,792,819.1 | 2,018.957.34 | 113.8 |
| Тайлант үеийн ашиг | 2,243,269,1 | 2,505,390.3 | 262.121.23 | 11.7 |
| 5. Эзэмшигчийн өмчийн дүн | 10,918,250,8 | 12,913,771,3 | 1,995.520.55 | 18.3 |
| Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн | 73,636,009,0 | 88,188,803,2 | 14.552.794.2 | 19.8 |

Орлогын тайлан/мян.төг/

| Санхүүгийн үзүүлэлт | Орлогын тайлан | | Өсөлт бууралт | |
|------------------------------------|--------------------|--------------------|---------------------|--------------|
| | 2022.12.31 | 2023.12.31 | дүнгээр | хувиар |
| Борлуулалт | 713.228.7 | 1.277.651.1 | 564,422,45 | 79.1 |
| Цэвэр борлуулалт | 713.228.7 | 1.277.651.1 | 564,422,45 | 79.1 |
| Ашиг | 713.228.7 | 1.277.651.1 | 564.422.45 | 79.1 |
| Үйл ажиллагааны зардал | 1.204.584.4 | 1,890,177,9 | 685.593.47 | 56.9 |
| Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал | 3.426.724.8 | 3,117,917,0 | (308.807.76) | -9.0 |
| Үүнд: Ноогдол ашгийн орлого | 492,289.6 | 10.635.380.1 | 10.143.090.54 | 2.060.4 |
| Хүү, хөрөнгө оруулалтын орлого | 7,238,700,0 | 13,147.0 | (7.225.553.04) | -99.8 |
| Валютын ханшийн ашиг алдагдал | (4.243.035.5) | (7.460.503.6) | (3.217.468.13) | 75.8 |
| Үйл ажиллагааны бус зардал | (61.229.3) | (70.106.4) | (8.877.13) | 14.5 |
| Татварын өмнөх ашиг | 2,935,369,1 | 2,505,390,3 | (429.978.79) | -14.6 |
| Татвар | 692.100.0 | | (692.100.0) | -100.0 |
| Цэвэр ашиг | 2,243,269,1 | 2,505,390,3 | 262.121.2 | 11.7 |

Тав. 2023 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэвшүүлсэн зорилтын биелэлтийн талаар

Ариг гал ХК нь хөрөнгө оруулалттай охин компаниудын үйл ажиллагааг дэмжиж, ажиллах нөхцлийг сайжруулж, хэвийн жигд найдвартай ажиллуулахын тулд КХ ХХК-ийн тусламжтайгаар дараахь ажлуудыг хийж хүлээн авлаа.

1. Ариг гал ХК-ийн дээврийн засварыг 5800 мкв талбайд 171.0 сая төгрөгийн зардлаар хийж гүйцэтгэлээ.
2. Компанийн борлуулалтыг дэмжиж гадаад дотоодын туршлагатай маркетингийн менежер, дизайнер, зөвлөхүүдийг ажиллуулж КХ ХХК-ийн борлуулалтыг 12,5 тэр бум төгрөгөөр, буюу 35%-иар борлуулалтыг нэмэгдүүлсэн.
3. Ариг Гал ХК-ийн Инженерийн шугам сүлжээг найдвартай ажиллагааг хангахын тулд төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх засварыг 78,6 сая төгрөгийг зарцуулж ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажлыг хүлээж авсан.
4. КХ ХХК-ийн хялгас ялгах үйлдвэрлэлийг хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэхийн тулд хятадаас бш иж бүрэн комплект шугмыг 2,5 тэрбум төгрөгөөр худалдан авсан бөгөөд шинэ цехийн барилга засвар, гэрэлтүүлэг, чийгшүүлэлтийн системийг технологийн дагуу монтажилж цехийг ашиглалтанд оруулсныг хүлээж авсан.
5. КХ ХХК-ийн 2022 онд 159тн ноолуур хүлээн авч байсан ба 2023 онд 186 тн ноолуурыг 13,77 тэрбум төгрөгөөр худалдан авснаар хялгас ялгах 12,3%-иар, ээрэх 34,5%-иар, сүлжих 15,1%, нэхэх 44,42%-иар үйлдвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлж ажилласан.
6. Хялгас ялгах цехийн хүчин чадлыг нэмэгдүүлж, экспортонд чанартай хялгасыг ялгасан ноолуур гаргахын тулд угаах цехэд сэгсрэх машин 235.0 сая төгрөгөөр, ээрэхийн утасны чанарыг сайжруулах зорилгоор италиас 170.0 сая төгрөгийн каретик, рукова, ремешок, автомат сүлжих цехийн сэлбэг, угаах индүүний хүчин чадлыг нэмэхэд 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснийг хүлээж авсан.
7. Ажилчдыг тав тухтай орчинд ажиллуулах, эмх цэгцтэй байлгах зорилгоор ширмэлийн үйлдвэрлэлийн сэндвичин ханыг 15.0 сая төгрөгөөр ажилчдын цайны газрын коридор, шат, хоол хийх засварт 50.0 сая төгрөг, нэхэх, ээрэх цехийн хананд 20.0 сая төгрөгийн засвар, цэвэр усны өрөөнд 9.0 сая төгрөг, программистуудын өрөөнд 6.0 сая төгрөг, ня-бо, няравуудын өрөөний засварт 5.0 сая төгрөг, будгийн цехийн ханын засварт 18.0 сая төгрөг, үйлдвэрийн баруун талын цонхны амлагааг хийх зардалд 10.0 сая төгрөг, хялгас ялгах цехийн засварт 28.0 сая төгрөг нийт 170.0 сая төгрөгийн зардлыг гаргаж гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

8. Эвсэг дэлгүүрийн гадна тохижилтыг сайжруулж гадна ханын засварт 9.0 сая төгрөг худалдааны заалны тохижилтонд 12.0 сая төгрөг, рекламны самбарт 5.0 сая төгрөг нийт 26.0 сая төгрөгийн засварыг хүлээж авсан.
9. Монгол ноолуурын сүлжмэл хувцас, ноолууран пальто пиджакийг борлуулахын тулд Япон, Солонгост дэлгүүр түрээслэн ажиллуулснаас гадна Хятад, АНУ, Англид онлайнаар зарах ажиллагааг эхлүүлсэн.
10. Компанийн хэмжээнд ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэхийн тулд:
 - а. Цэцэрлэгт 40 гаруй хүүхдийг хамруулсан.
 - б. ХХ ХХК-12, ЭО ХХК-2, ГМ ХХК-2, ХШ ХХК-7, ММ ХХК-9, Эвсэг ХХК-2 нийт 34 ажилтанд орон сууцны урьдчилгаанд хамруулж 958.0 мянгөн төгрөгийн зардал гаргасан.
 - в. ҮК-иудаас сонгон шалгаруулж 3 ажилтанд ШУТИС-д 11,7 сая төгрөгөөр сургаж байна.
 - г. Гаднаас 4 менежменттэй холбоотой сургалт авахад 14,4 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.
 - д. Нийгмийн хариуцлагын хүрээнд ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэхээр 27 ажилтанд 22,656.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлээ.
 - е. Компанийн ажилтнуудын ажлын үр дүн, шинэ санаа, ажлын гүйцэтгэлийн чанарыг сар бүр багаар хэлэлцүүлж 106,512,052 төгрөгийн урамшуулалыг олгосон байна.

Зургаа. Компанийн удирдлага зохион байгуулалтын талаар

“Ариг Гал” ХК-ийн удирдлагын бүтэцэд өөрчлөлт ороогүй, ХЭХ, ТУЗ, ТУЗ-ийн даргын АА гэсэн бүтцээрээ ажиллаж байгаа.

Ариг гал группийн хэмжээнд Ариг гал ХК-ийн охин компани болох Метро политан проперти ХХК, Блю скай тауэр ХХК, Кашмер холдинг ХХК-иуд үйл ажиллагаагаа явуулсан хэвээр байна.

Кашмер холдинг ХХК-ийн охин компани болох утас ээрэх үйлдвэрлэлийн Хавт шонхор ХХК, сүлжих үйлдвэрлэлийн Монмяндас ХХК, нэхэх үйлдвэрлэлийн Эвсэг од ХХК, ширмэл үйлдвэрлэлийн Тансаг ширээс ХХК, зөөлөн оёмолын үйлдвэрлэлийн Говийн мяндас ХХК, борлуулалтын Эвсэг ХХК-иуд үйл ажиллагаа явуулж байгаа.

Эдгээр Компаниудын ажлыг сар бүр ТУЗ-д туслах чиг үүрэгтэй ТУЗ-ийн даргын АА нь дүгнэж байр эзлүүлэн, ажлын үр дүнгээр нь шагнаж урамшуулах, сүүлийн байранд орсон компанийн удирдлагад хариуцлага тооцох асуудлыг ТУЗ-ийн даргад тавьж шийдвэрлүүлэх, ажлыг үр дүнтэй явуулах зорилгоор шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж, тус шалгуур үзүүлэлтээр компаниудын чадамжийг тогтоож, жилийн ажлаар нь урамшуулан ажилласан.

Ариг гал ХК-ийн ТУЗ-ийн хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн дарга нь АА-аараа дамжуулан бүх компаниудыг нэгдсэн менежментийн бодлого, удирдлагаар хангаж ажилласан.

Долоо. Сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцлийн талаар

Тус компани нь Группийн толгой компанийн үндсэн үүргээр ноолуурын үйлдвэрлэлийн охин компаниуддаа ноолуур бэлтгэлийн эргэлтийн хөрөнгө, үйлдвэрлэл өргөтгөх, технологийн сайжруулалт, шинэ тоног төхөөрөмж худалдан авах, шинэчлэх үйл ажиллагааны санхүүжилтэд нь зориулж бусад байгууллага, банк, ББСБ-аас зээл олж өгөх, зээлд хөрөнгийн барьцаа, батлан даалт гаргах зэргээр эх орныхоо “сэргээгддэг баялаг” болсон Монгол ямааны ноолуурын боловсруулалтын үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагааг дэмжих зохицуулалт бүхий бодлогыг баримталж, хэрэгжүүлж ажиллаж ирсэн.

Тус компанийн ТУЗ-ийн гишүүдийн 55.5% нь өөрийн охин компани болох Кашмер холдинг ХХК-иас сонгогдсон гишүүд байгаагаас дээрх бодлогын хүрээнд охин компаниудад үзүүлж байгаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх ТУЗ-ийн шийдвэр нь “Компанийн тухай хууль”-ийн 89.1.3 дугаар зүйлд зааснаар сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдож байгаа болно.

Иймд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хурлын хараат бус гишүүдийн 100%-ийн саналаар 05.23 тоот тогтоол гарч, Мөн ноос ХК-иас зээл

авах зөвшөөрөл олгож, 19.0 тэрбум /арван есөн тэрбум/-төгрөгийн зээлийг “Кашмер холдинг” ХХК-ийн түүхий эдийн, Хавт шонхор ХХК-д тоног төхөөрөмжийн зээл олгож, зээлийн эх үүсвэрээр үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлж технологи хөгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Найм. Хувьцаа эзэмшигчдийн тухай танилцуулах нь

Одоогийн байдлаар компанийн 3749320ш хувьцааг 7270 хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа нь өмнөх оноос 1,3%-иар хувьцаа эзэмшигчдийн тоо буурсан нь хувьцааны төвлөрөл үргэлжилж байгаа гэж харж байна. Компани нь халаасны хувьцааг 9,4%-иар нэмэгдүүлсэн өнөөдрийн байдлаар 3,6%-ийг халаасалсан байгаа.

Тус компанийн хувьцааны 52.4%-ийг нэгдмэл сонирхолтой этгээд болох Эрч нийгэмлэгээр 19.99%, Ээрүүл нийгэмлэгээр 19.99-ийг эзэмшиж байгаа бөгөөд эдгээр нийгэмлэгүүдийн гишүүд нь Ариг гал группийн харьяа компаниудад ажилладаг ажилтнууд байгаа. ТУЗ-ийн дарга хувьцааны 12.4%-ийг эзэмшиж байгаа хэвээр.

Эдгээр нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь тухайн үед мөрдөж байсан үнэт цаасны тухай хуулийн дагуу 1995-онд компанид болон СЗХ-нд нэгдмэл сонирхолтой болох тухайгаа мэдэгдэж бүртгүүлсэн, МХБ-ийн веб сайтад байршуулж нийтэд мэдээлэгдсээр ирсэн.

Компанийн хувьцааны 44.0%-ийн хувьцаа нь 7269 хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байна

Ес. Ногдол ашгийн хуваарилалтын тухай.

Тус компани 2022 онд нэгж хувьцаанд 39,90 төгрөг хуваарилж, ногдол ашигт 138,8 сая.төг-ийг 2023 оны 1 сард тараасан. Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 сарын 18-ны өдрийн 06/22 тоот тогтоолоор 2022 оны ногдол ашигт нэгж хувьцаанд 67,47 төгрөг хуваарилж, 224,3 сая.төг-ийг зарцуулахаас 88.9 сая.төгрөг нь нийгэмлэгт байгаа сул хувьцаанд төлөх үлдэгдлээр өглөгөөр бүртгэгдээд байгаа. Энэ нь одоо ажиллаж байгаа ажилтнуудаас нийгэмлэгээр дамжуулж хувьцаа эзэмшсэн тохиолдолд олгогдоно.

ТУЗ-ийн 2024 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хурлаас 2023 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн 11.13%-иар буюу нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийг 80.00 төг-өөр (наян төгрөг 00 мөнгө)-өөр, буюу нийт 278345.6 мянган төгрөг (хоёр зуун далан найман сая гурван зуун дөчин таван мянга зургаан зуун) -ийг хуваарилахаар шийдвэр гаргасан байна.

Арав. Цаашид хийх ажил

1. Үйлдвэрлэлийн компаниудын үйл ажиллагаа, үр ашгийг дээшлүүлэх, ажиллах орчныг сайжруулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх.
2. Компанийн үл хөдлөх хөрөнгө, газар зэргийг барьцаалж эргэлтийн хөрөнгийн зээл авахад дэмжлэг үзүүлэх.
3. Компанийн гадаад, дотоод борлуулалтыг нэмэгдүүлэхийн тулд Америкийн Амазон, Хятадын Тови, ТИК ТОК, онлайн сайт дээр бараа зарах, Япон, Солонгос, Германд дэлгүүр ажиллуулах үйл ажиллагааг дэмжих.
4. Шинээр нарийн номерын утсаар бүтээгдэхүүн хийх ажлыг сайжруулж үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх.
5. Үйлдвэрлэлийн технологийн дамжлагын хаягдлыг дахин ашиглаж зөөлөн тоглоом, ширмэл хөнжил хийх, хүүхдийн хувцас үйлдвэрлүүлэх ажиллагааг дэмжиж ажиллах.
6. Ажилчдын оролцоотой компаниудын шинэ бизнесийн үйл ажиллагааг дэмжих. Үүнд:
 1. Хүүхдийн хувцасны брэнд бий болгох.
 2. Үндэсний хувцасны үйлдвэрлэлтийг эхлүүлж борлуулалтыг нэмэгдүүлэх.
 3. Цэвэр ус савлаж борлуулах.
 4. Хүргэлтийн үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг болно.

“АРИГ ГАЛ” ХК-ИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД АУДИТЫН ХОРООНООС ӨГСӨН ДҮГНЭЛТ

Нэг. Санхүүгийн тайлан тэнцэл, хөрөнгө өр төлбөрийн өнөөгийн байдлаар талаар

Компанийн нийт хөрөнгө 88,2 тэрбум төгрөгт хүрч, тайлант жилийн хугацаанд 14,6 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлт нь үндсэндээ эргэлтийн хөрөнгийн өсөлттэй холбоотой байна. Хөрөнгийн эх үүсвэрийн хувьд өр төлбөрийн хэмжээг 12,5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Группийн толгой компанийн үүрэг гүйцэтгэн охин компаниудын үйл ажиллагааг зохицуулах, санхүүжилтийн эх үүсвэрээр хангах үйл ажиллагаа эрхэлж байгаа учраас группийн доторх хоорондын тооцооны өглөг авлага, дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд дансны авлага 64,6 тэрбум төгрөгөөс 63,8 төгрөг нь охин компани болох Кашмер холдинг ХХК-аас авах авлага байна. Дансны өглөг болох 74,2 тэрбум төгрөгөөс 46,8 тэрбум төгрөг нь Тэргүүн оюун ХХК-аас 2010 онд авсан 21,0 сая долларын өрийн үлдэгдэл өглөг /ханшийн өсөлтийг хэсэгчлэн тусгасан/, 1,7 тэрбум нь Шандас импес ХХК-д өгөх өглөг, 19,7 тэрбум төгрөг нь ажил төрлийн холбоотой, дэмжлэг үзүүлсээр ирсэн Монноос ХК-аас авсан хөнгөлөлттэй зээлийн өр байна. Группийн компаниудад санхүүгийн эх үүсвэр бүрдүүлж өгөх зорилгоор өр үүсдэг учраас өр авлагын хэмжээ харьцангуй ойролцоо байх ёстой боловч дансны өр нь дансны авлагаас бараг 10,0 тэрбум төгрөгөөр илүү байгаагийн шалтгааныг тайлбарлах хэрэгтэй гэж үзэж байна.

Хоёр. Орлого

Ариг гал ХК нь үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг охин компаниудад шилжүүлж, үйл ажиллагааг нь зохицуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг хангах зэргээр холдингийн толгой компанийн үүргийг гүйцэтгэн ажиллаж байгаа учраас нь орлогын эх үүсвэр нь:

| | |
|---------------------|------------------------|
| А. Ногдол ашиг | 10635,4 сая төгрөг |
| Б. Түрээсийн орлого | 1277,7 сая төгрөг |
| В. Хүүгийн орлого | 13,1 сая төгрөг байна. |

Түрээсийн орлогын хувьд өсөлт байгаа нь эрчим хүч болон дулааны төлбөрийг гэрээ бүхий Ариг гал ХК-аас авах болсонтой холбоотой байна.

Мөн компанид олон жил хадгалагдсан цаашид ашиглах боломжгүй сэлбэг хэрэгсэлийг балансын үнээр нь ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг компанид борлуулж, энэ асуудал үндсэндээ шийдвэрлэгдсэн гэж үзэж болохоор байна.

Гурав. Зардал

Тайлант онд үйл ажиллагааны зардал 9420,8 сая төгрөг болж, өмнөх оныхоос 1,7 дахин өссөн. Үүнд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, /газрын асуудлаас шалтгаалан гарсан хуулийн зөвлөх үйлчилгээний зардал/, цахилгаан дулааны төлбөрийн өсөлттэй холбоотой байна.

Үйл ажиллагааны бус зардал нь үндсэндээ ханшийн өсөлтийн 7460,0 сая төгрөг байна. 2023 онд валютын ханш огцом өссөнөөс шалтгаалан ажил төрлийн холбоо бүхий компаниудаас валютаар авсан зээлийн өрөөс шалтгаалан 7,4 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн байна.

Дөрөв. Санхүү эдийн засгийн ерөнхий төлөв

Санхүү эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүд өнгөрсөн оны түвшингээс ахисан байна. Энэ онд санхүүгийн үйл ажиллагаанаас өндөр орлого олсон төдийгүй хөрөнгө оруулалтаар үйлдвэрлэл үйлчилгээг өргөтгөх, ажилны нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэргээр

нилээдгүй ахиц гаргаж чадсан байна. Үүнд:

1. Ариг гал ХК-ийн дээврийн засварыг 5800 мкв талбайд 171.0 сая төгрөгийн зардлаар хийж гүйцэтгэлээ.
2. Компанийн борлуулалтыг дэмжиж гадаад дотоодын туршлагатай маркетингийн менежер, дизайнер, зөвлөхүүдийг ажиллуулж КХ ХХК-ийн борлуулалтыг 12,5 тэр бум төгрөгөөр, буюу 35%-иар нэмэгдүүлсэн.
3. Ариг Гал ХК-ийн Инженерийн шугам сүлжээг найдвартай ажиллагааг хангахын тулд төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх засварыг 78,6 сая төгрөгийг зарцуулж ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажлыг хүлээж авсан.
4. КХ ХХК-ийн хялгас ялгах үйлдвэрлэлийг хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэхийн тулд хятадаас бш иж бүрэн комплект шугамыг 2,5 тэрбум төгрөгөөр худалдан авсан бөгөөд шинэ цехийн барилга засвар, гэрэлтүүлэг, чийгшүүлэлтийн системийг технологийн дагуу монтажилж цехийг ашиглалтанд оруулсныг хүлээж авсан.
5. КХ ХХК-ийн 2022 онд 159тн ноолуур хүлээн авч байсан ба 2023 онд 186 тн ноолуурыг 13,77 тэрбум төгрөгөөр худалдан авснаар хялгас ялгах 12,3%-иар, ээрэх 34,5%-иар, сүлжих 15,1%, нэхэх 44,42%-иар үйлдвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлж ажилласан.
6. Хялгас ялгах цехийн хүчин чадлыг нэмэгдүүлж, экспортонд хялгасыг ялгасан ноолуур гаргахын тулд угаах цехэд сэгсрэх машин 235.0 сая төгрөгөөр, ээрэхийн утасны чанарыг сайжруулах зорилгоор италиас 170.0 сая төгрөгийн каретик, рукова, ремешок, автомат сүлжих цехийн сэлбэг, угаах индүүний хүчин чадлыг нэмэхэд 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснийг хүлээж авсан.
7. Ажилчдыг тав тухтай орчинд ажиллуулах, эмх цэгцтэй байлгах зорилгоор ажилчдын цайны газрын коридор, шат, хоол хийх цехийн засварт 50.0 сая төгрөг, үйлдвэрлийн цехийн болон конторын дотоод засварт нийт 170.0 сая төгрөгийн зардлыг гаргаж гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.
8. Эвсэг дэлгүүрийн гадна тохижилтыг сайжруулах, худалдааны заалны тохижилт, г, рекламны самбарт хийх зэрэгт нийт 26.0 сая төгрөгийн засварыг хүлээж авсан.
9. Монгол ноолуурын сүлжмэл хувцас, ноолууран пальто пиджакийг борлуулахын тулд Япон, Солонгост дэлгүүр түрээслэн ажиллуулснаас гадна Хятад, АНУ, Англид онлайнаар зарах ажиллагааг эхлүүлсэн.
10. Компанийн хэмжээнд ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэхийн тулд:
 - а. Цэцэрлэгт 40 гаруй хүүхдийг хамруулсан.
 - б. Нийт 34 ажилтанд орон сууцны урьдчилгаанд хамруулж 958.0 сая төгрөгийн зардал гаргасан.
 - в. 3 ажилтанд ШУТИС-д 11,7 сая төгрөгөөр сургаж байна.
 - г. Гаднаас 4 менежменттэй холбоотой сургалт авахад 14,4 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.
 - д. Нийгмийн хариуцлагын хүрээнд ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэхээр 27 ажилтанд 22,656.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлээ.
 - е. Компанийн ажилтнуудын ажлын үр дүн, шинэ санаа, ажлын гүйцэтгэлийн чанарыг сар бүр багаар хэлэлцүүлж 106,512,052 төгрөгийн урамшуулалыг олгосон байна.
11. Үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд 409-р хорих ангитай хамтран ажиллаж зөөлөн оёдлын 30ш машин, сүлжихийн оёх машин 30ш-ийг суурилуулж сар бүр 5000/6500ш бүтээгдэхүүн үйлдвэрлүүлж авдаг болсон байна.

Дүгнэлт

Өнгөрсөн жилийн тайлангаар үүрэг даалгаврууд үндсэндээ хэрэгжсэн байна. Мөн түүнчлэн энэ жилийн үйл ажиллагааны тайлан нь өнгөрсөн жилүүдийнхтэй харьцуулахад агуулгын хувьд дэлгэрэнгүй сайн болсныг тэмдэглэх нь зүйтэй.

Мөн түүнчлэн дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлэх ажилд онцгой анхаарал хандуулж, одоо Кашмер холдинг ХХК-ийн бүрэлдэхүүнд байгаа дотоод аудитын албыг Ариг гал компанийн бүрэлдэхүүнд шилжүүлж, жинхэнэ утгаар нь хараат бус байдлаар ажиллуулах нь зүйтэй гэж үзэж байна.

ТУЗ-ийн зүгээс компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан нь компанийн бодит байдлыг бүрэн зөв тусгасан бөгөөд гүйцэтгэх баг нь тавьсан зорилгоо үндсэнд нь биелүүлж сайн ажилласан гэсэн дүгнэлт өгснийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

ТУЗ-ИЙН АУДИТЫН ХОРОО